

2026

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ

ЦООХОР ИРВЭС БҮХИЙ ОРНУУДЫН ЗАСГИЙН
ГАЗРУУДАД ХҮРГҮҮЛЭВ

NO. 13 ЦООХОР ИРВЭСНИЙ АМЬДРАХ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГ БА БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ
NO. 15 ХҮНИЙ АШИГ СОНИРХОЛД ЗЭРЛЭГ АМЬТНЫ УЧРУУЛСАН ХОХИРЛООС ҮҮДЭЛТЭЙ ЗӨРЧЛИЙН МЕНЕЖМЕНТ
NO. 16 ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БА БАЙГАЛИЙН ӨГӨӨЖИЙН ҮНЭЛГЭЭ БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ
NO. 17 БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ЛАНДШАФТ ДАХЬ ОРОЛЦООН ДЭЭР СУУРИЛСАН МОНИТОРИНГ, ҮНЭЛГЭЭ (PM&E)



АГУУЛГА

Бодлогын зөвлөмж No. 13 (Шинэчилсэн найруулга): ЦООХОР ИРВЭСНИЙ АМЬДРАХ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГ БА БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ (Анхны хэвлэл 2022 оны 10 сарын 23) 4

- УДИРТГАЛ..... 5
- ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ 7
- ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГАЧЛАЛЫН ТАВАН ЧИГЛЭЛ 9
- БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ ДАХЬ ОРОН НУТАГТ ТҮШИГЛЭСЭН АЖ АХУЙН НЭГЖҮҮД (ОНТАН) 16
- ХЭРЭГЖИЛТ 20

Бодлогын зөвлөмж No. 15: Хүний ашиг сонирхолд зэрлэг амьтны учруулсан хохирлоос үүдэлтэй зөрчлийн менежмент..... 22

- Удиртгал ба нэр томьёо..... 23
- Ёс зүйтэй, хамтран боловсруулах хандлагын ач холбогдол. 25
- Гол зарчмууд ба хэрэгжилт 26
- Байгууллагуудад учрах сорилтуудыг даван туулах 28

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ No. 16: Экосистемийн үйлчилгээ ба байгалийн өгөөжийн үнэлгээ 29

- Удиртгал ба үндэслэл 30
- Экосистемийн үйлчилгээний ач холбогдол 32
- Гол зарчмууд ба хэрэгжүүлэх арга замууд..... 34
- Зөрчлийг бууруулах ба байгууллагуудад учрах сорилтууд. 36

АГУУЛГА

- Шүүмжлэлийг шийдвэрлэх болон хөгжиж буй
тогтолцоонууд38

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ No. 17: Байгаль хамгааллын

ландшафт дахь оролцоон дээр суурилсан мониторинг,

үнэлгээ (PM&E)41

- Удиртгал ба үндэслэл42
- ОСМУ-ний ач холбогдол44
- Үндсэн зарчмууд46
- ОСМУ-г практикт хэрэгжүүлэх нь48
- Байгууллагын түвшний сорилтуудыг даван туулах нь50

**Бодлогын зөвлөмжийг боловсруулахад гол хувь нэмэр оруулсан
хүмүүс (цагаан толгойн үсгийн дарааллаар).....52**

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ NO. 13 (ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА):

ЦООХОР ИРВЭСНИЙ АМЬДРАХ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСАГ БА БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

(АНХНЫ ХЭВЛЭЛ 2022 ОНЫ 10 САРЫН 23)

УДИРТГАЛ

Дэлхийн хуурай газар дахь амьдрах орчны талбай асар ихээр тасралтгүй хумигдан өөрчлөгдөж, хуурай газар болон далай тэнгисийн зэрлэг ургамал, амьтдын хэт ашиглалт, бохирдол, уур амьсгалын өөрчлөлт, үүнээс үүдэн экосистем доройтож байгаа нь манай гарагийн байгаль орчны хямрал, төрөл зүйл олноор устах аюул заналыг учруулж байна (Дасгупта 2021). Эдгээр өөрчлөлтүүд нь байгаль орчныг үл тоомсорлож, эдийн засгийн өсөлтийг нэгдүгээрт тавьдаг орчин үед зонхилж байгаа хөгжлийн загвараас үүдэлтэй юм. Энэхүү сөрөг өөрчлөлтийг зогсоохын тулд биологийн олон янз байдлыг хамгаалахын зэрэгцээ эдийн засгийн хөгжлийг дэмжих хандлага зайлшгүй шаардлагатай байна. Тиймээс энэ бодлогын зөвлөмж нь ихэвчлэн олон талт үйл ажиллагаа явагддаг бүс нутаг болох нийгэм-экологийн тогтолцооны төлөөлөл-цоохор ирвэсний нутаг дэвсгэр дэх хөгжлийн загварт зориулагдсан болно. 2017 онд Киргиз улсын Ерөнхийлөгчийн ивээл дор тус улсын Засгийн газар Бишкек хотноо Цоохор ирвэс болон экосистемийг хамгаалах олон улсын хоёрдугаар форумыг зохион байгуулсан.



2017 онд Киргиз улсын Ерөнхийлөгчийн ивээл дор тус улсын Засгийн газар Бишкек хотноо Цоохор ирвэс болон экосистемийг хамгаалах олон улсын хоёрдугаар форумыг зохион байгуулсан.

Энэхүү арга хэмжээний хүрээнд цоохор ирвэс бүхий орнуудын хөрөнгө оруулалтын орчныг танилцуулах, экологийн хувьд тогтвортой, байгальд хор хөнөөлгүй салбаруудын хөрөнгө оруулалтын боломжийг судлахыг хувийн хэвшлийнхэнд уриалах зорилгоор "Ногоон хөрөнгө оруулалтын форум"-ыг зохион байгуулсан юм. Тус форум нь цоохор ирвэсний нутаг дэвсгэрт байгаль хамгааллын үйл ажиллагааг эсэргүүцэх бус, харин дэмжихүйц хөрөнгө оруулалтыг татах боломжийг нээж өгсөн. Мөн эдийн засгийн хөгжлийн төлөө байгаль хамгааллыг нэн тэргүүнд тавих хөгжлийн хандлага хэрэгтэй байгааг онцлон тэмдэглэв. Цоохор ирвэс бүхий 12 улс хамтран гаргасан "Бишкекийн тунхаглал 2017"-д экосистемийн үйлчилгээний эдийн засгийн үнэлгээг хийхийг эрмэлзэхийн зэрэгцээ ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих, ногоон дэд бүтцийг үндсэн чиглэл болгох шаардлагатайг тодорхойлсон байдаг. Энэхүү зөвлөмж нь 2017 оны "Ногоон хөрөнгө оруулалтын форум"-ын үйл ажиллагааны үргэлжлэл бөгөөд бодлогын арга хэмжээ авах үзэл баримтлалын чиглэлийг гаргаж байгаа юм.


ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ

Хамгаалалт болон тусгаарлалтад тулгуурласан дэлхийн байгаль хамгааллын хүчин чармайлт болон хэрэглээ, үйлдвэрлэлийн цар хүрээнд тулгуурласан эдийн засгийн хөгжил нь хоорондоо зөрчилдөж, бие биедээ сөрөг үр дагавар авчирсаар ирсэн (Folke 2006). Чухам иймээс л эдийн засаг болон экологийг уялдуулах дэлхийн хөгжлийн өөр хувилбар нь хүн төрөлхтөнийг илүү тогтвортой гараг руу чиглүүлэх боломжтой юм.

Энэхүү бодлогын зөвлөмж нь биологийн олон янз байдлыг хамгаалах болон экосистемийн үйлчилгээний тогтвортой ашиглалтад тулгуурласан эдийн засгийн хөгжлийн хандлагыг тодорхойлсон болно. Ийм хандлага нь байгалийн нөөц ашиглалтыг тогтвортой хөгжлийн хязгаар болон манай гарагийн байгалийн тогтсон хил хязгаар дотор байлгах боломжийг олгоно (Steffan et al. 2015). Энэ нь үйлдвэрлэлийн цар хүрээг чухалчлахаас илүүтэйгээр өртгийн эдийн засагт анхаарлаа хандуулдаг бөгөөд орон нутгийн экосистем, соёл, экосистемийн үйлчилгээний тогтвортой ашиглалт болон биологийн олон янз байдлыг хамгаалахад оруулж буй хувь нэмэртэй нь уялдуулан түүхий эд, бүтээгдэхүүний нэмүү өртгийг бий болгодог.

"Хөгжлийн төлөөх байгаль хамгаалал" –ын гол зорилго нь биологийн олон янз байдал болон экосистемийн үйлчилгээний хамгаалалт, тогтвортой ашиглалтад тулгуурласан, орон зайн хувьд тодорхой, өөрчлөлт шинэчлэлт авчирахуйц хөгжлийн загварыг бий болгоход оршино (Зураг 1).

ЗУРАГ 1: ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ОНОЛ



Энэхүү аргачлал нь орон зай болон нөхцөл байдлын хувьд нарийн тодорхой байхад чиглэсэн бөгөөд биологийн олон янз байдал, соёл, эдийн засгийн сайн сайхан байдлыг хамгаалахад чиглэсэн дараах үндсэн таван чиглэл дээр тулгуурладаг. Үүнд:

1. Тодорхой орон зай дахь байгаль хамгааллын тогтолцоо
2. Экосистемийн үйлчилгээнд чиглэсэн байх
3. Тогтвортой өртөг бүхий аж ахуйн нэгжийн загвар
4. Нийгэм-эдийн засгийн оролцоог хангах
5. Өргөн хүрээний түншлэл


Энэхүү аргачлалыг богино болон урт хугацааны үр дүнтэй байхаар төсөөлж болно. Богино хугацааны үр дүнд: "Хөгжлийн төлөөх байгаль хамгаалал" аргачлалыг улс төрийн түвшинд дэмжүүлэх; нөөц бололцоо болон мэдлэг туршлага шилжүүлэх хөрөнгө оруулагчдыг татах; орон нутгийн иргэд болон бизнес эрхлэгчдийг идэвхитэй оролцож, хариуцлага хүлээхэд нь урамшуулах, дэмжлэг үзүүлэх зэрэг багтана. Урт хугацааны үр дүнд: Засгийн газрын дэмжлэг, дэлхийн хэмжээний хөрөнгө оруулагчид болон орон нутгийн түншлэлүүд нь биологийн олон янз байдлыг хамгаалахын зэрэгцээ тухайн бүс нутагт эдийн засгийн хөгжлийг хангаж, хүний сайн сайхан амьдралыг цогцлооход нөлөөлнө.





ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГАЧЛАЛЫН ТАВАН ЧИГЛЭЛ

1. ТОДОХОЙ ОРОН ЗАЙ ДАХЬ БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО

"Хөгжлийн төлөөх байгаль хамгаалал" аргачлалын хүрээнд тухайн нутаг дэвсгэрийг экологийн онцгой бүс болгон тогтоож, биологийн олон янз байдлын үнэ цэнэ, экосистемийн үйлчилгээний нөөц ба урсгал, газрын эзэмшил болон хүний одоогийн ашиглалт дээр үндэслэн зураглал хийдэг. Орон нутгийн иргэд, төрийн холбогдох байгууллагууд болон бусад талуудтай хамтран тухайн нутаг дэвсгэрийг тусгай хамгаалалттай газар нутгийн бүсчлэлтэй ижил зарчмаар 3-аас 4 бүсэд ангилдаг (Зураг 2). Нөхцөл байдлаас шалтгаалан зэрлэг амьтны чухал амьдрах орчин болон экосистемийн үйлчилгээний нөөц бүсийг нэг ангилалд нэгтгэж болно. Бүс бүрт тохирсон сөрөг нөлөөллийг бууруулах шат дараалсан арга хэмжээг эдийн засгийн өсөлтийн зорилтуудыг хангахын зэрэгцээ биологийн олон янз байдал, экосистемийн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэхээр боловсруулдаг.

Зураг 2. ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ" ЗАГВАРЫН ХҮРЭЭНД ЭКОЛОГИЙН ОНЦГОЙ БУСУУДИЙН ЗУРАГЛАЛЫГ ГАРГАХ, БҮСЧЛЭХ БОЛОН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ШАТ ДАРААЛАЛ



-  **ЗЭРЛЭГ АМЬТНЫ ОНЦГОЙ БУС (ТУСГААРЛАЛ)**
-  **ЭС-ИЙН НӨӨЦ БУС (ХЯЗГААРТАЙ БУС)**
-  **ЭС-ИЙН АШИГЛАЛТЫН БУС (НУТАГШУУЛАХ)**
-  **ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БУС**



Зэрлэг амьтны онцгой бүс

- Нэн тэргүүний зорилт: Биологийн олон янз байдал ба Зэрлэг амьтны хамгаалал
- Сөрөг нөлөөллийг бууруулах шатлал: ТУСГААРЛАЛ
- Дэд бүтэц болон амьдрах орчныг хориглох
- Судалгаа, мониторинг ба хамгаалал
- Бүс нутагт хяналттай нэвтрэх, судалгааны хүрээнд богино хугацаанд буудаллах
- Бэлчээрийн нөлөөллийг маш бага хэмжээнд барих
- Урт хугацаанд зэрлэг амьтны популяцийн (N_c) даац болон (K), үржлийн үеийн нөхцөлийг хангах (bc) хорогдлын түвшинг бууруулах (mc), нүүдэллэн гарах түвшин (ec) нүүдэллэн ирэх түвшинээс харьцангуй их байх (ic) дам нөлөөг бий болгох:
 - $N_c \approx K$,
 - $bc > mc$,
 - $ec \gg I$.



Экосистемийн үйлчилгээний нөөц бүс

- Тэргүүлэх чиглэл: Ой мод, амьдрах орчин болон экосистемийн үйлчилгээг хамгаалах
- Сөрөг нөлөөллийг бууруулах шат дараалал: ЗАЙЛСХИЙХ / ХАМГИЙН ДООД ТҮВШИНД ХҮРТЭЛ БУУРУУЛАХ
- Байгаль орчныг доройтуулах эсвэл бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх
- Экосистемийн үйлчилгээний нөөцийг тодорхойлж, хамгаалалтад авах
- Голын сав газрын хүн амд очих экосистемийн үйлчилгээний урсгалыг тасралтгүй хангах
- Судалгаа шинжилгээ, мониторинг болон хамгаалалт
- Тогтвортой энергийн хэмнэлт бүхий дэд бүтэц
- Зэрлэг амьтдын тоо толгойг (N_{es}) урт хугацааны туршид орчны даацад (K) ойр түвшинд хадгалах; төрөлтийн түвшин (b_{es}) нь нас баралтын түвшнээс (m_{es}) давах нөхцөлийг бүрдүүлэх; мөн "хальж тархах нөлөө"-г (spill-over effects) бий болгохын тулд гадагш шилжих хөдөлгөөний түвшин (e_{es}) нь дотогш шилжих хөдөлгөөний түвшнээс (i_{es}) өндөр байх:
 - $N_{es} \approx K$
 - $b_{es} > m_{es}$
 - $e_{es} > i_{es}$



Экосистемийн үйлчилгээний ашиглалтын бүс

- Тэргүүлэх чиглэл: Хүний сайн сайхан байдлын төлөөх экосистемийн үйлчилгээний ашиглалт

- Сөрөг нөлөөллийг бууруулах шатлал: БАГАСГАХ / СЭРГЭЭН ЗАСАХ
- Малын бэлчээр, зөгийн аж ахуй болон цэвэр ус гэх мэт экосистемийн бусад үйлчилгээний зохистой ашиглалт.
- Судалгаа шинжилгээ, мониторинг болон хамгаалалт.
- Амьжиргааг дэмжих байгаль орчинд нөлөө багатай дэд бүтэц.
- Хадгалан хамгаалалт болон экосистемийн үйлчилгээний ашиглалтын зорилтуудын хоорондын хамаарлаас шалтгаалан зэрлэг ан амьтдын тоо толгойн зохистой хэмжээг (N_{eh}) тооцоолж, тоо толгойг тухайн түвшинд барих: $N_{eh} = K - f(N)$, $b_{eh} + i_{eh} \leq m_{eh} + e_{eh}$
 Үүнд, $f(N)$ нь экосистемийн хангамжийн үйлчилгээг зохистой түвшинд ашигласны үр дүнд зэрлэг амьтдын тоо толгой орчны багтаамжаас (K) хэрхэн буурахыг харуулсан функц юм.



Эдийн засгийн хөгжлийн бүс

- Тэргүүлэх чиглэл: Үйлдвэрлэл болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
- Сөрөг нөлөөллийг бууруулах шатлал: ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ (OFFSET) Хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэр болон бусад үйлдвэрлэл, эдийн засгийн тусгай бүсүүд.

Бүсчлэл, ашиглалт болон нөлөөллийг бууруулах шат дараалсан энэхүү арга барил нь байгаль хамгааллын хүчин чармайлт болон газар ашиглалтын төлөвлөлтийн үндэс суурь болж чадна. Тухайлбал, зэрлэг амьтдын чухал бүс нутаг болон экосистемийн үйлчилгээний нөөц бүсүүд хамтдаа ердийн тусгай хамгаалалттай газар нутагтай ижил зорилгоор үр дүнтэй үйлчилдэг.


Экосистемийн үйлчилгээний ашиглалтын бүс нь байгалийн нөөц баялгийг тогтвортой ашиглах (жишээ нь: бэлчээр, усалгааны ус, ахуйн хэрэглээний ус, эмийн ургамал, эко аялал жуулчлал) боломжийг олгодог бол эдийн засгийн хөгжлийн бүс нь дэд бүтэц, үйлдвэрлэл, орон сууц болон аж ахуйн нэгжүүдийн бусад хэрэгцээнд зориулагддаг. Энэ бүсэд байгуулагдсан бүх аж ахуйн нэгжүүд нь тогтвортой байдлын бусад холбогдох стандарт, гэрчилгээг хангахаас гадна байгаль хамгаалал болон экосистемийн үйлчилгээний энэхүү орон зайн тодорхой тогтолцоог дагаж мөрдөх ёстой. Гэсэн хэдий ч одоо байгаа газар ашиглалтын системээс ялгаатай нь энэхүү загварт янз бүрийн бүсүүд болон үйл ажиллагаанууд нь ихэвчлэн хоорондоо холбогдож, бие биедээ нөөц баялгийн эх үүсвэр болж өгдөг.

2. ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГОЛ ЧИГЛЭЛ

Хөгжлийн төлөөх байгаль хамгааллын аргачлалд тухайн газар нутгийг зөвхөн эдийн засгийн өсөлтийг дэмжигч хөдөлгүүр, эсвэл экосистемийн үйлчилгээний эх үүсвэр гэж хардаггүй. Мөн биологийн олон янз байдлыг чандлан хамгаалах халдашгүй бүс нутаг болгохоор төсөөлдөггүй. Харин үүний оронд биологийн олон янз байдал болон экосистемийн үйлчилгээний (ES) нөөцийг хадгалан үлдэж, экосистемийн үйлчилгээг хүний сайн сайхан, эдийн засгийн өсөлтөд тогтвортой ашиглах ёстой нийгэм-экологийн харилцан хамаарал бүхий систем гэж үздэг (Зураг 3).

Иймд энэхүү арга барил нь дараах зүйлсийг агуулна: (i) нийгэм болон газар эзэмшлийн талаар иж бүрэн ойлголттой болох, тухайн газар нутгийн экосистемийн үйлчилгээний эдийн засаг, нийгэм-соёлын үнэлгээг хийж, зураглал гаргах; (ii) биологийн олон янз байдлыг хамгаалахын зэрэгцээ хүмүүсийн сайн сайхны төлөө экосистемийн үйлчилгээний ашиглалтыг оновчтой болгох, хүмүүсийн өвөрмөц онцлог болон тэдний үнэт зүйлийн орон зайг хамгаалах, нийгмийн сайн сайхан байдлыг дэмжих, нийгэм-экологийн системийн тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх менежментийн тогтолцоог бүрдүүлэх; (iii) засаглал болон менежментийн байгууллагуудаас тогтоосон хяналтын дагуу менежментийн тогтолцоо болон бусад тогтвортой байдал, баталгаажуулалтын системд нийцсэн аж ахуйн нэгжүүдийг байгуулах гэсэн гол чиглэлүүдтэй байна.

БҮСЧЛЭЛ



ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Малын тэжээл
Талбайн усалгаа
Цэвэр ус агаар
Тоос хүртэлт
Байгалын гамшиг элэгдлээс аюулгүй байх
Шүтлэгтэй газар
Онцлогт байдал

ХҮНИЙ САЙН САЙХАН

Аюулгүй байдал
Нөөцийн аюулгүй байдал
Хангалттай амьдрал
Тэжээллэг хоол хүнс
Эрүүл мэнд
Нийгмийн харилцаа сайн
Сонгох эрх чөлөө ба үйл ажиллагаа



ЗУРАГ 3: ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ЗАГВАРЫН ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД СУУРИЛСАН ДҮРСЛЭЛ (EDZ: ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН БҮС, ESHZ: ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АШИГЛАЛТЫН БҮС, ESSZ: ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨӨЦ БҮС, CWZ: ЗЭРЛЭГ АМЬТДЫН ЧУХАЛ БҮС).

3. ТОГТВОРТОЙ ҮНЭЛГЭЭ БҮХИЙ БИЗНЕСИЙН ЗАГВАР

Хөгжлийн төлөөх байгаль хамгааллын арга барилын гол цөм нь тоо хэмжээнээс илүү үнэ цэнийг эрхэмлэдэг, экологийн хувьд тогтвортой арилжааны аж ахуйн нэгжүүд байх болно. Жишээлбэл, хөдөө аж ахуйн салбар дахь орон нутгийн уламжлалт давуу талыг олон төрлийн шинэлэг технологи, туршлагатай хослуулснаар хүнсний ногоо, жимс жимсгэнэ, эслэгээс эхлээд боловсруулсан бүтээгдэхүүн хүртэлх байгаль орчинд хор хөнөөл багатай, органик бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэх боломжтой (Fernandez et al. 2013). Эдгээр бүтээгдэхүүнүүд нь дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд хурдтай өсөн нэмэгдэж буй хэрэглэгчдийн зах зээлд нэвтрэх боломжтой (Rahmaniah et al. 2020).

Мал аж ахуйн менежментийн орон нутгийн туршлагыг мах, сүүн бүтээгдэхүүний сав баглаа боодол, хадгалалт, тээвэрлэлтийн технологитой хослуулснаар үйлдвэрлэлийн аргаар мал өсгөхөөс өөр сонголт бий болж, өвөрмөц онцлогтой бүтээгдэхүүн санал болгодог жижиг (niche) бизнесүүдийг хөгжүүлэх боломжийг олгоно (Howe et al. 2018). Үүний тулд салбарын онцлог бүхий мэргэжлийн ур чадвар, тогтвортой байдлын шинжлэх ухааны ойлголт, технологийн ерөнхий мэдлэг болон бизнес менежментийн чадвартай, олон талт ур чадвар бүхий сайн бэлтгэгдсэн ажиллах хүчнийг бэлдэх шаардлага гарна. Эдгээр ур чадварыг олгох сургалт явуулахын зэрэгцээ орон нутгийн иргэдэд үнэ цэнийг бий болгох зорилгоор байгуулагдсан аж ахуйн нэгжүүд нь эдийн засгийн амин чухал бүрэлдэхүүн хэсэг болж чадна.

4. НИЙГЭМ – ЭДИЙН ЗАСГИЙН ТЭГШ БАЙДАЛ

Хөгжлийн төлөөх байгаль хамгааллын арга барил нь нийгэм, эдийн засаг, улс төр болон экологийн асуудлууд хоорондоо нягт холбоотой болохыг хүлээн зөвшөөрдөг. Нийгэм-эдийн засгийн тэгш бус байдал нь байгаль орчны доройтлыг нэмэгдүүлэхэд хүргэж болзошгүй юм. Энэхүү арга барилын хамгийн чухал хэсэг бол нийгмийн янз бүрийн саад бэрхшээл, эрх мэдлийн бүтэц болон бусад холбогдох талуудыг үл харгалзан орон нутгийн нийгмийн бүх давхаргыг татан оролцуулах явдал юм. Орон нутгийн бизнес эрхлэгчдийг ашиг олохоос гадна ажлын байр бий болгох эсвэл сургалт явуулах замаар орон нутгийн иргэдийн дийлэнх хэсэгт үр өгөөжөө өгөх, үнэ цэнд төвлөрсөн бизнесүүдийг бий болгоход нь дэмжлэг үзүүлдэг.

5. ӨРГӨН ХҮРЭЭНИЙ ТҮНШЛЭЛ

Олон улсын шинжээчдийн сүлжээ болон байгууллагуудын оролцоо нь эдийн засагт нэн чухал юм. Даяаршиж буй өнөөгийн ертөнцөд дэлхийн нэг хэсэгт боловсруулсан технологийг өөр нэг хэсгийн бизнесүүдэд шилжүүлэн нэвтрүүлэх нь орон нутгийн болон дэлхийн эдийн засагт хамтын ажиллагааны үр өгөөж (synergy) болон үнэ цэнийг бий болгодог. Орон нутгийн аж ахуйн нэгжүүд бусад зах зээл эсвэл бүс нутагт хэдийн бий болсон хөрс, ус, газар тариалангийн менежмент, байгаль хамгаалал болон сургалтын тодорхой технологи, арга барилуудыг нэвтрүүлснээр үр ашиг хүртэх боломжтой.

ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ ТУРШЛАГАТАЙ КОМПАНИУДАЙ ХАРИЛЦАН АШИГТАЙ АРИЛЖААНЫ ТҮНШЛЭЛ ТОГТООХ НЬ ОРОН НУТГИЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД БИЗНЕСИЙН ШИНЭ ЗАГВАРУУДЫГ НЭВТРҮҮЛЭХ, ДЭЛХИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ХЭРЭГЛЭГЧДЭД ЗОРИУЛСАН ҮНЭ ЦЭНИЙН ДАВТАГДАШГҮЙ САНАЛУУДЫГ БИЙ БОЛГОХОД ТУСАЛНА.

Аж ахуйн нэгжүүдийн өсөлтөд санхүүгийн хөрөнгө оруулалт нэн чухал ач холбогдолтой байх болно. Байгалийн экосистемийг хамгаалахын зэрэгцээ эдийн засгийн хөгжилд ашиглах хэрэгцээ шаардлагаас үүдэн дэлхийн байгаль хамгааллын санхүүжүүлэгчдийн хүрээлэлд сүүлийн үед урамшууштай өсөлт ажиглагдаж байна. Өр төлбөр, хувьцаа болон буцалтгүй тусламжийн санхүүжилт зэрэг инновацлаг санхүүгийн хэрэгслүүдийг өргөнөөр ашиглаж эхлээд байна (Бергхофер нар, 2017). Ийм боломжууд нь энэхүү ногоон эдийн засгийн хөрөнгө оруулалтын шаардлагыг хангахад туслах боломжтой юм. Энэхүү хүрээлэл дэх хөрөнгө оруулагчид нь ихээхэн чинээлэг хувь хүмүүсээс эхлээд аливаа сан болон үндэсний баялгийн сангуудыг хамардаг.

БАЙГАЛЬ ХАМГААЛАЛ ДАХЬ ОРОН НУТАГТ ТҮШИГЛЭСЭН АЖ АХУЙН НЭГЖҮҮД (ОНТАН)

"Тогтвортой үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийн загвар" болон "Нийгэм-эдийн засгийн тэгш байдал" гэсэн тулгуур зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд Орон нутагт түшиглэсэн аж ахуйн нэгжүүдийг (ОНТАН) байгуулах нь нэн чухал юм.

ОНТАН гэж юу вэ?

Аж ахуйн нэгж гэдэг нь орлого олж, ашиг хүртэхийн тулд зах зээлд бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх эсвэл үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажилладаг байгууллага юм. Орон нутагт түшиглэсэн аж ахуйн нэгжүүд (ОНТАН) нь нутгийн иргэд эсвэл орон нутгийн иргэдийн өмчлөлд байж, тэдний удирдлага, хяналт дор үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд юм. Эдгээр нь орон нутгийн хэрэгцээг хангах, орон нутгийн байгалийн нөөцийг ашиглах, мөн нийгэм, эдийн засаг болон хүрээлэн буй орчинд үр ашиг авчирхайц ашигтай бараа, үйлчилгээ үйлдвэрлэхэд анхаардаг. ОНТАН нь зөвхөн нийгмийн санаачилга биш бөгөөд тогтвортой амьжиргааг бий болгох, эдийн засгийн бие даасан байдлыг сайжруулах, илүү өргөн хүрээний зах зээлд үйлчлэхүйц хэмжээнд өргөжих гэсэн эдийн засгийн тодорхой зорилтуудыг агуулдаг.

Түүхээс үзвэл, ОНТАН-ууд нь 1970 болон 1980-аад онд хөгжлийн бодлого төвлөрсөн эдийн засгийн загвараас иргэдийн оролцоонд тулгуурласан загварт шилжих үед үүссэн. Өнөөдөр тэд орон нутгийн эдийн засгийн хөгжил, нийгмийн эв нэгдэл, байгаль орчны тогтвортой байдлын чухал эх үүсвэр болж байна.

Байгаль хамгаалалд ОНТАН-дийн нэн тэргүүний хэрэгцээ

Түүхээс үзвэл, байгаль хамгааллын хүчин чармайлтууд нь дээрээс доош чиглэсэн (төвлөрсөн) шинжтэй байсан нь ихэвчлэн орон нутгийн иргэдийг нутаг зааж нүүлгэх, нөөц баялгийн ашиглалтыг хязгаарлахад хүргэж, улмаар ээдрээтэй зөрчил мөргөлдөөнийг бий болгодог байв. Харин 1990-ээд он гэхэд байгаль хамгааллыг орон нутгийн иргэдтэй хамтран хэрэгжүүлэх шаардлагатайг нийтээрээ хүлээн зөвшөөрөх болсон. Энэхүү шинэ хандлага нь аж ахуйн нэгжүүдээр дамжуулан орон нутгийн иргэдийн эдийн засгийн чадавхийг бэхжүүлэхийн ач холбогдлыг тодорхойлсон юм.

Сүүлийн гучин жилийн хугацаанд байгаль хамгаалалд чиглэсэн эдгээр бизнесүүд нь байгаль хамгаалал, нийгмийн тэгш байдал болон эдийн засгийн ашигт ажиллагааг тэнцвэржүүлэх буюу "гурвалсан үр ашиг" (triple bottom line)-ийг цогцлоохыг зорьж ирсэн.

Үндсэн шинж чанарууд:

- **Орон нутгийн иргэдийн өмчлөл:** Өмчлөх эрх болон шийдвэр гаргах эрх мэдэл нь үндсэндээ орон нутгийн иргэдийн гарт байна.
- **Байгаль хамгааллын чиг баримжаа:** Эдийн засгийн үйл ажиллагааг хүрээлэн буй орчныг хамгаалах үйлстэй уялдуулах.
- **Нөөц баялгийн тогтвортой ашиглалт:** Экологийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах.
Эдийн засгийн чадавхижуулалт ба оролцоог хангах: Орлого бий болгох, нийгмийн эмзэг бүлгүүдийг (эмэгтэйчүүд, залуучууд, нутгийн иргэд) нийгмийн амьдралд татан оролцуулах.
- **Орлогын дахин хуваарилалт:** Ашгийг орон нутгийн хөгжил эсвэл байгаль хамгааллын санаачилгад буцаан хөрөнгө оруулах.
- **Экосистемийн үйлчилгээний үнэлэмж:** Эко-аялал жуулчлал, ойн бус бүтээгдэхүүн болон соёлын өвийг баялаг (актив) болгон ашиглах.

Тогтвортой ОНТАН-ийг бий болгоход учрах саад бэрхшээл

- **Хэт ашиглалт ба богино хугацааны төвлөрөл:** Шууд ашиг олохыг эрмэлзэх нь байгаль хамгааллын зорилгод харшлах тогтворгүй олборлолт, үйл ажиллагаанд хүргэж болзошгүй.
- **Зах зээлийн эмзэг байдал:** Тодорхой нэг зах зээлээс (жишээ нь, эко-аялал жуулчлал) хэт хамааралтай байх нь аж ахуйн нэгжийг эдийн засгийн хэлбэлзэл, геополитикийн болон нийгмийн зөрчил мөргөлдөөн, эсвэл цар тахалд өртөмтгий болгодог.
- **Гадаад хамаарал:** Төрийн байгууллага, ТББ эсвэл донор байгууллагуудаас хэт хамааралтай байх нь орон нутгийн өмчлөх эрхийг сулруулж, санхүүжилт зогсох үед аж ахуйн нэгж дампуурахад хүргэдэг.
- **Эрх мэдлийн тэнцвэргүй байдал ба бие даасан байдлаа алдах:** Хөндлөнгийн байгууллагууд шийдвэр гаргахад давамгайлж, орон нутгийн соёл эсвэл экологийн бодит байдалд нийцэхгүй загваруудыг тулгах эрсдэлтэй.
- **Засаглал ба тэгш бус байдал:** Ашиг хонжоо хайх сэдэл нь авлигыг өдөөж, ашгийн удирдлага муу байх нь үр өгөөжийн тэгш бус хуваарилалт болон нийгмийн хурцадмал байдлыг бий болгож болно.
- **"Гринвошинг" (Greenwashing):** Зах зээлийг татахын тулд байгаль орчинд ээлтэй мэтээр худал дүр эсгэж, хор хөнөөлтэй үйл ажиллагаагаа нуун дарагдуулах.

ОНТАН –ийг бий болгох: Зөвлөмж

Шийдэл ба Стратеги

Эдгээр сорилтуудыг даван туулахын тулд орон нутгийн хүчтэй манлайлал, орлогын олон эх үүсвэр болон засаглалын ил тод байдлыг чухалчилсан стратегийн хандлага зайлшгүй шаардлагатай.

- **Орон нутгийн жинхэнэ өмчлөлийг дэмжих:** Иргэдийг анхнаас нь татан оролцуулах. Манлайлах чадвартай бизнес эрхлэгчдийг тодруулахын тулд оролцоонд тулгуурласан үйл явцыг зохион байгуулах.
- **Байгаль хамгаалал ба амьжиргааг уялдуулах:** Экологийн хязгаартай нийцсэн эко-аялал жуулчлал, экосистемийн үйлчилгээний тогтвортой ашиглалт болон нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнээр дамжуулан тогтвортой орлого бүрдүүлэх.
- **Орон нутгийн чадавхыг бэхжүүлэх:** Экологийн хяналт-шинжилгээ, бизнесийн удирдлага болон зөрчлийг шийдвэрлэх сургалтуудыг эртнээс явуулах. Урт хугацааны менторшип (зөвлөх үйлчилгээ) тогтоох.
- **Ил тод засаглал:** Итгэлцлийг бэхжүүлэхийн тулд бүх талын оролцоог хангасан удирдлагын хороодоор дамжуулан шийдвэр гаргах, үр өгөөжийг хуваарилах шударга дүрмийг бий болгох.
- **Уян хатан бизнесийн загварууд:** Орлогын олон эх үүсвэртэй, уян хатан аж ахуйн нэгжүүдийг байгуулах. Цаг хугацааны явцад хөндлөнгийн байгууллагуудаас хамааралтай байдлыг багасгах.
- **Зах зээл ба түншлэл:** Байгаль хамгаалал болон орон нутгийн чадавхижуулалтыг онцолсон хүчтэй брэнд хөгжүүлэх. Шинэ зах зээлд нэвтрэхийн тулд стратегийн түншлэлийг бий болгох.
- **Санхүүгийн удирдлага ба хяналт:** Ил тод нягтлан бодох бүртгэлийг хэрэгжүүлэх. Экологийн нөлөөлөл, нийгмийн үр ашиг болон санхүүгийн гүйцэтгэлийг тогтмол хянах.performance.



ХЭРЭГЖИЛТ

Цоохор ирвэсийн тархац нутагт "Хөгжлийн төлөөх байгаль хамгаалал" хандлагыг үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд туслах зорилгоор Дэлхийн цоохор ирвэс, түүний экосистемийг хамгаалах хөтөлбөрийн (GSLEP) нарийн бичгийн газар болон түншүүд нь байгаль хамгаалалтай уялдсан тогтвортой эдийн засгийн хөгжлийн аж ахуйн нэгжүүдэд зориулсан платформ болон брэндийн төрхийг (EQUAL ONE) бий болгосон. Ийм нэгдсэн платформ болон брэндийн төрх нь энэхүү үзэл баримтлалыг өөр өөр салбар, түвшинд нэвтрүүлэхэд туслах бөгөөд үүнд газар дээрх бодит хэрэгжилтээс эхлээд бодлогын дэмжлэг хүртэлх бүх шат дамжлага хамаарна.

Ийм платформын гол шинж чанарууд болон түүний өгөх үр ашгуудад дараах зүйлс багтана:

- Хэлэлцүүлэг өрнүүлэх боломж: Оролцогч талууд (хувь хүмүүс, нөлөөлөгчид, орон нутгийн иргэд) болон байгууллагууд (төр засаг, аж ахуйн нэгж, брэндүүд) хоорондоо зөвшилцөж, байгалийн амьдрах орчинд (хүн, амьтан, ургамал) ээлтэй бизнесийн арга барилыг хамтран бүтээх боломжийг олгоно.
- Мэдлэг, туршлагыг нэгтгэх: Төрөл бүрийн төслүүдээс хуримтлуулсан мэдлэг, туршлагыг нэгтгэж, харилцан суралцахад туслах ашигтай нөөц боломжуудыг бий болгоно.
- Хүрээгээ тэлэх: Үр шим хүртэгчдийн сүлжээг байгуулснаар үзэл санаагаа улам өргөжүүлэх бөгөөд тэдгээр иргэдийн ихэнх нь үзэл бодол нэгт хамт олон, түншүүд болно. Тэд өөрсдийн мэдлэг, хөрөнгө, нөөц бололцоо, бүтээгдэхүүн үйлчилгээний багц, хүсэл тэмүүлэл болон нөлөөллөөрөө уг хөтөлбөрийг улам бүр өргөжүүлдэг.
- Хэрэгцээнд суурилсан дэмжлэг: Орон нутгийн бизнес эрхлэгчид эсвэл иргэдэд экологид ээлтэй, нийгмийн оролцоог хангасан, соёлын онцлогт нийцсэн бөгөөд эдийн засгийн үр ашиг авчирахуйц бизнесээ байгуулахад нь туслахын тулд төрөл бүрийн хэрэгцээт дэмжлэгүүдийг санал болгоно.
- Итгэлцлийг нэмэгдүүлэх: Өртгийн сүлжээний ил тод, хянах боломжтой байдлыг хангах, бүтээгдэхүүн үйлчилгээний чанарын хяналтыг сайжруулах, экологи, нийгэм болон эдийн засгийн тогтвортой байдлыг баталгаажуулснаар хөрөнгө оруулагчид болон худалдан авагчдын итгэлийг нэмэгдүүлнэ.
- Холбоо тогтоох, туршлага хуваалцах: Ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, нэгдмэл үнэт зүйлтэй хүмүүсийг хооронд нь холбож, бие биенээ дэмжих, харилцан суралцах болон хамтдаа хөгжих боломжийг бүрдүүлнэ. Нийгэм болон байгаль орчны тогтвортой байдлын зорилтод хүрэхийн тулд мэдлэг, нөөц бололцоогоо бусадтайгаа солилцох үйл явцыг хөнгөвчилнө.
- Үр шим хүртэгчид: Төсөл хөтөлбөрүүд, хувь хүмүүс, бүлгүүд, байгууллага, аж ахуйн нэгжүүд, бүтээгчид эсвэл өөрчлөлтийг хурдасгуулагчид платформын үр шимийг хүртэх боломжтой.
- Санхүүжилт ба нөөцийн дэмжлэг: Орон нутгийн иргэдийн дундаас төрөн гарч буй ирээдүйтэй бизнес эрхлэгчдийг санхүүжилт болон нөөцөөр дэмжинэ. Цоохор ирвэс тархсан улс орнууд (Range countries), GSLEP-ийн түншүүд болон олон улсын санхүүгийн байгууллагууд орон нутгийн стартапуудыг дэмжихэд хөрөнгө оруулалт хийх боломжтой.
- Бодлогын уялдаа холбоо: Цоохор ирвэс бүхий улс орнууд өөрсдийн төсөл, бодлогодоо "Equal One" хүрээ үзэл баримтлалыг тусган нэвтрүүлэхийг авч үзэж болно.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ НО. 15:

Хүний ашиг сонирхолд зэрлэг амьтны учруулсан хохирлоос үүдэлтэй зөрчлийн менежмент



Удиртгал ба нэр томьёо

“Хүн-зэрлэг амьтны хоорондын зөрчил” хэмээх нэр томьёог зэрлэг амьтад хүний амь нас, амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлж буй нөхцөл байдлыг тодорхойлоход өргөн ашигладаг. Гэвч энэ нэр томьёо нь хүн ба зэрлэг амьтдын хооронд шууд, дайсагнасан сөргөлдөөн байгаа мэт утгыг илэрхийлдэг. Энэ нь ихэнх тохиолдолд үнэндээ хүмүүсийн хоорондын зөрчил (нэг тал нь төрөл зүйлийг хамгаалахыг эрхэмлэдэг бол нөгөө тал нь хүмүүсийн аюулгүй байдал, амьжиргааг хангахыг эрмэлздэг үнэт зүйл, ашиг сонирхлын зөрүү) байдаг нарийн төвөгтэй нөхцөл байдлыг хэт хялбаршуулж үзэх эрсдэлтэй юм.

Тиймээс “хүн-зэрлэг амьтны хоорондын зөрчил” гэх нэр томьёо эсвэл түүний хувилбаруудыг ашиглахаас татгалзаж, эдгээр нөхцөл байдлыг байгаль хамгааллын зөрчил эсвэл зүгээр л зэрлэг амьтдын учруулсан хохирол гэж нэрлэх нь зүйтэй.

Эдгээр нөхцөл байдлыг хоёр хэсэгт хуваан ойлгож болно:

- a. Хүний ашиг сонирхолд зэрлэг амьтдын учруулсан хохирол.
- b. Хүмүүс зэрлэг амьтад өсөрхөх эсвэл урьдчилан сэргийлэх зорилгоор хууль бус үйлдэл хийх



Хүн ба зэрлэг амьтад зэрэгцэн оршиход хүний ашиг сонирхолд тодорхой хэмжээний хохирол учрах нь гарцаагүй гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм. Жишээлбэл, тариалангийн талбай болон мал сүрэг нь зэрлэг амьтдын хувьд анхаарал татахуйц нөөц баялаг болдог. Зэрлэг амьтдын ойр орчимд ийм нөхцөл байдал үүсэх үед зөрчлийг бүрмөсөн арилгах боломжгүй бөгөөд хамгийн сайн шийдэл нь түүнийг зөв зохистой удирдах явдал юм.

Төрийн байгууллагууд, оролцогч болон бусад дэмжигч талуудын хувьд энэ асуудлыг "зөрчлийг устгах эсвэл шийдвэрлэх" гэхээс илүүтэй "зөрчлийн менежмент ба зэрэгцэн оршихуй" гэж өөрчлөн тодорхойлох нь бодлогын чухал шилжилт юм. Экологийн шинжлэх ухаан, уламжлалт мэдлэг, соёл, хүйс, тэгш байдлын хүний хүчин зүйлс болон "чөлөөт, урьдчилсан, мэдээлэл бүхий зөвшөөрөл" (Free Prior and Informed Consent -FPIC) зэрэг ёс зүйтэй засаглалын тогтолцоог нэгтгэснээр Засаг захиргааны байгууллагууд болон институцууд биологийн олон янз байдлын үндэсний зорилтууд, олон улсын нийгмийн хамгааллын бодлого, хүний эрхийн үүрэг амлалтуудтай нийцсэн зөрчлийг бууруулах тогтвортой стратегийг боловсруулах боломжтой.

Ёс зүйтэй, хамтран боловсруулах хандлагын ач холбогдол

Байгаль хамгааллын зөрчлийг ёс зүйтэй, орон нутгийн иргэдэд түшиглэсэн загвараар шийдвэрлэх нь байгаль хамгаалагчид, төрийн байгууллагууд, олон улсын байгууллагууд болон орон нутгийн оролцогч талуудад хэд хэдэн тодорхой давуу талуудыг бий болгодог. Үүнд:

- a. Анхаарлыг "асуудалтай амьтан"-ыг буруутгахаас илүүтэй "асуудлын нөхцөл байдал"-д (жишээ нь: улирлын давхцал, мал сүргийн эмзэг байдал, том махчин эсвэл өвсөн тэжээлтэй эр амьтдын эрсдэлтэй зан төрх) чиглүүлснээр байгаль орчны байгууллагууд нөхцөл байдалд зөвхөн хариу үйлдэл үзүүлэх бус, шинжлэх ухаан болон уламжлалт мэдлэгт суурилсан урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой болно.
- b. Амьтны учруулсан хохиролд үзүүлэх хүний хариу үйлдэл нь тухайн орчны соёл, эрх мэдлийн динамик болон хүйсийн харилцаанаас (жишээ нь: эмэгтэйчүүд зэрлэг амьтдын учруулсан гарзын улмаас хоол тэжээлийн дутагдал эсвэл сэтгэл санааны дарамтад илүү өртдөг) ихээхэн хамаардаг. ТҮНШЛЭЛ- (PARTNERS Principles¹)-ийн зарчим зэрэг тогтолцоог ашиглах нь зөрчлийн менежментэд нийгмийн цөөнх буюу орхигдсон дуу хоолойг оролцуулахын зэрэгцээ тэгш хөгжлийн зорилт болон нийгмийн хамгааллын бодлогыг шууд хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг.

1 <https://snowleopard.org/our-work/conservation-programs/partners-principles-overview/>

- c. **Эмпати (бусдыг ойлгох сэтгэл) болон шуурхай хариу арга хэмжээ нь зөрчлийн менежментийн үндэс суурь юм.** Яаралтай бөгөөд энэрэнгүй дэмжлэг үзүүлэх протоколуудыг (жишээ нь: шуурхай хариу арга хэмжээний хяналтын хуудас) бий болгох нь иргэдийн уур бухимдлыг бууруулж, амьтдыг өсөрхөн хороохоос сэргийлж чадна.
- d. **Зэрлэг амьтдыг өөр газар нүүлгэн шилжүүлэх эсвэл тоо толгойг нь цөөлөх зэрэг дээрээс доош чиглэсэн, тэр дор нь хариу үйлдэл үзүүлэх шинжтэй арга хэмжээнүүд нь ихэвчлэн шүүмжлэлд өртдөг, зардал өндөртэй, экологийн хувьд үр дүнгүй байх нь бий.** Харин хамтран боловсруулсан хандлагаар дамжуулан орон нутгийн иргэдийг тухайн нөхцөл байдлыг даван туулах чадварыг нэмэгдүүлэх тэдний оролцоо, хариуцлагыг дээшлүүлэх нь төрийн байгууллагуудын хууль сахиулах урт хугацааны ачааллыг хөнгөвчилдөг.

Гол зарчмууд ба хэрэгжилт

Зөрчлийн менежментийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд стратегиуд нь дээрээс тулгасан бус, тухайн орон нутгийн нөхцөл байдалд гүн гүнзгий нийцсэн бөгөөд нөлөөлөлд өртсөн иргэдтэй хамтран боловсруулсан байх ёстой.

1. Зөвхөн нэг аргад (жишээ нь: нөхөн олговор) найдах нь учир дутагдалтай. Төрийн салбар нэгжүүд болон төслийн менежерүүд дараах цогц аргуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм:
 - a. **Хохирлыг бууруулах:** Биет хаалтуудыг (махчин амьтнаас хамгаалсан хашаа, саравч) амьтдын зан төрхөд нөлөөлөх үргээгч хэрэгсэл болон сонор сэрэмжтэй хослуулах.
 - b. **Гарзыг нөхөн төлөх:** Урьдчилан тааварлах боломжгүй гарз хохиролд шударга, тодорхой нөхөн олговор олгох; иргэдийн хариуцлагыг нэмэгдүүлж, хуурамч нөхөн олговор хүсэх асуудлыг бууруулах зорилгоор орон нутгийн удирдлагатай даатгалын тогтолцоог дэмжих.
 - c. **Зэрэгцэн оршихуйг дэмжих:** Эко аялал жуулчлал зэрэг байгаль хамгаалалтай холбоотой амьжиргааны эх үүсвэрүүд болон танин мэдэхүйн хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн хохирлыг даван туулах чадварыг нэмэгдүүлэх.
2. Зөрчлийн голомт цэгүүд, улирлын хандлага болон орон нутгийн мэдлэгийг зураглах:
 - a. **Хамтын ажиллагаа:** Орон нутгийн иргэдтэй хамтран шийдэл боловсруулж, зардал, засвар үйлчилгээний хариуцлага болон шийдвэр гаргах эрх мэдлийг тодорхой хуваарилах.
 - b. **Туршилтаар эхэлж, урт хугацаанд дэмжих:** Том газар нутгийг хамархаас өмнө хяналт тавьж болохуйц жижиг хэсгүүдэд шийдлүүдийг туршиж, нотолгоо болон итгэлцлийг бий болгох.
 - c. **Хяналт үнэлгээг хийж хэрэгцээ шаардлагад нийцүүлэх:** Зөрчлийн тохиолдлууд, орон нутгийн иргэдийн амьжиргаан үзүүлэх нөлөө болон иргэдийн итгэлцлийн түвшинг мэдэхийн тулд оролцоонд суурилсан мониторинг үнэлгээний аргуудыг ашиглах; ингэснээр гомдол барагдуулах, засч залруулах тодорхой механизмыг бүрдүүлнэ.
3. Иргэдтэй ажиллахдаа нутгийнханы болон тэндхийн засаг захиргааны тогтолцоог хүндэтгэх нь зүйтэй. Мэдээлэл болон мэдлэгийн бүрэн эрхт байдлыг (жишээ нь: OCAP болон CARE зарчмууд) дээдэлж, иргэд өөрсдийн мэдлэгээ эзэмших, мөн байгаль хамгаалал, зөрчлийн менежментийн түншлэлээс бодит бөгөөд шударга ашиг хүртэх нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй.



Байгууллагуудад учрах сорилтуудыг даван туулах

Зөрчлийн менежментийг тэр дор нь хариу үйлдэл үзүүлээд шийдэхээсээ илүүтэй урьдчилан сэргийлэх, зэрэгцэн оршиход суурилсан гэх мэт цогц аргачилал руу шилжүүлэхийн тулд тогтсон санхүүжилтийн систем болон хүнд суртлын саад бэрхшээлийг даван туулах шаардлагатай:

1. Ганц нэгээр нь авч хэрэгжүүлдэг, нүдэнд харагдахуйц арга хэмжээнүүд эсвэл амьтдыг нүүлгэн шилжүүлэх зэрэг туйлширсан бодлого нь хүмүүст хурдан үр дүн авчрах мэт санагддаг ч ихэнхдээ асуудлын үндсэн шалтгааныг шийдэж чаддаггүй. Оролцогч талууд болон улсын төлөвлөгөө боловсруулагчид нь бодит хохирол болон нийгмийн сайн сайхан байдлыг хоёуланг нь хамарсан, урт хугацааны, цогц зэрэгцэн орших стратегийг санхүүжүүлэх үүрэг амлалт авах ёстой.
2. Итгэлцлийг бий болгоход цаг хугацаа шаардагддаг. Засаг захиргаад болон донорууд нь байгаль хамгааллын мэргэжилтнүүдэд туршилтын арга хэмжээнүүдийг багаас нь эхлэх боломжийг олгох уян хатан төсвийг гаргаж өгөх хэрэгтэй. Үйл ажиллагааны цар хүрээг тэлэх ажлыг зөвхөн орон нутгийн итгэлцэл, гүйцэтгэлийн чадавх болон тухайн төсөл хөтөлбөр үр дүнтэй байх нь нотлогдсоны дараа л гүйцэтгэх ёстой.
3. Төрийн байгууллагууд болон томоохон институцууд нь энэхүү зөрчлийн менежментийн асуудлыг цогцоор нь захиргааны дүрэм журмандаа тусгахын тулд туршлагатай манлайлагчид болон төрийн бус түншүүдтэй хамтран ажиллаж болно. Үүнд яаралтай тусламжийг шуурхай үзүүлэх, ёс зүйн тогтолцоог (жишээ нь: PARTNERS зарчим) стандарт ажиллагааны журам (SOP) болон гамшгийн үед авах хариу арга хэмжээний протоколуудад тусгах зэрэг ажлууд багтана.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ NO. 16:

Экосистемийн үйлчилгээ ба байгалийн өгөөжийн үнэлгээ



Удиртгал ба үндэслэл

Эдийн засгийн өсөлт болон байгаль орчны доройтлыг удаан хугацааны турш бие биенээ үгүйсгэгч хүчин зүйлс гэж үзэж ирсэн бөгөөд хөгжилд хүрэхийн тулд ойн хомсдол, амьдрах орчны алдагдал, бохирдол зэрэг золиосыг гаргах ёстой гэж үздэг байв. Энэхүү зөрчилдөөнийг байгалиас улс орнуудын эдийн засагт оруулж буй үлэмж хэмжээний боловч ихэнхдээ "үл үзэгдэх" хувь нэмрийг эс тоомсорлодог уламжлалт эдийн засгийн загварууд улам гүнзгийрүүлж байна. Үүнээс үүдэн экосистемүүд дутуу үнэлэгдэж, хэтрүүлэн ашиглагдаж, доройтоход хүрдэг.

Байгалийн өгөөжийг тодорхой болгох зорилгоор экосистемийн үйлчилгээ хэмээх ойлголтыг боловсруулсан. Экосистемийн үйлчилгээ гэдгийг хүний сайн сайхан байдалд шууд болон шууд бусаар хувь нэмэр оруулж буй байгалийн, холимог эсвэл хүний нөлөөгөөр өөрчлөгдсөн экосистемийн үр ашиг, гарц гэж тодорхойлдог. Экосистемийн үйл явцыг зөвхөн хүн ашиг хүртэж буй тохиолдолд л "үйлчилгээ" гэж нэрлэх бөгөөд "экосистемийн үйлчилгээ" болохын тулд эцсийн үр шимийг хүртэгч нь хүн байх шаардлагатай.



Төрийн байгууллагууд, оролцогч талууд болон хөгжлийн төлөвлөгөө боловсруулагчдын хувьд экосистемийн үйлчилгээг шийдвэр гаргах түвшинд тусгах нь зөвхөн байгаль орчны сонголт биш, харин макро эдийн засгийн зайлшгүй шаардлага юм. Хамгийн чухал нь экосистемийн доройтол нь үндэсний эдийн засгийн тогтвортой байдалд шууд бөгөөд системчилсэн эрсдэл учруулж буй нөхцөл байдлыг тэнцвэржүүлэх нь нэн чухал. Энэхүү эрсдэл нь:

- a. Үерийн аюулыг сааруулаагүйгээс үүдэн гамшгийн дараах нөхөн сэргээлтийн зардал нэмэгдэх;
- b. Байгалийн тоос хүртээгчид үгүй болсноор хөдөө аж ахуйн ургац буурах;
- c. Байгалийн нөөцөөс хамааралтай хөдөө орон нутгийн амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлэх зэргээр бодит санхүүгийн алдагдал болон хувирдаг.

Байгалиас нийгмийн амьдралд оруулж буй хувь нэмрийг хүлээн зөвшөөрч, тэдгээрийн үнэлгээг баталгаажуулснаар засгийн газрууд эдийн засгийн урт хугацааны тэсвэрлэх чадварыг бэхжүүлэн, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, нийгэм-байгаль орчны өртөг өндөртэй зөрчлөөс урьдчилан сэргийлж чадна. Экосистемийн үйлчилгээний тогтолцоог ажил хэрэг болгох нь бодлогын амин чухал шилжилт боловч эдийн засгийн системүүд өнөөг хүртэл үнэ төлбөргүй ашиглаж ирсэн нөөц баялагтаа (экосистемийн үйлчилгээ) аудит хийхээс (эсвэл нөхөн төлөхөөс) татгалздаг тул үүнийг хэрэгжүүлэхэд хүндрэл гардаг. Байгалийг зөвхөн "зардлын төв" эсвэл "үнэгүй зүйл" гэж хардаг хандлагыг өөрчилж, хүлээн зөвшөөрөгдсөн байгалийн капитал болгон хувиргах нь амаргүй юм. Гэсэн хэдий ч эдгээр үнэт зүйлийг дотооддоо шингээснээр засгийн газар болон байгууллагууд үндэсний эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг биологийн олон янз байдлын олон улсын амлалтуудтай тэнцвэржүүлж, хүн төрөлхтний сайн сайхан байдал болон орон нутаг, үндэсний болон дэлхийн эдийн засгийн үндэс суурь болсон үйлчилгээнүүдийг тогтвортой ашиглах боломжийг бүрдүүлж чадна.

Экосистемийн үйлчилгээний ач холбогдол

Экосистемийн үйлчилгээг ойлгож, ангилах нь төрийн байгууллагууд болон байгаль хамгаалагчдад байгалийн нийгэмд үзүүлж буй олон талт үнэ цэнийг тодорхой илэрхийлэх боломжийг олгодог. Экосистемийн үйлчилгээ нь үндсэн гурван ангилалд хуваагддаг:

- a. **Хангамжийн үйлчилгээ:** Үүнийг таримал ургамал, байгалийн гаралтай бүтээгдэхүүн, цэвэр ус болон мод бэлтгэл зэрэг амьд тогтолцооноос гарч буй хүнс, материаллаг болон эрчим хүчний бүтээгдэхүүн гэж тодорхойлж болно.
- b. **Зохицуулах үйлчилгээ:** Үүнийг амьд организмууд хүрээлэн буй орчныг тэнцвэржүүлэх замаар хүмүүст үзүүлж буй ашиг тус гэж тодорхойлдог. Үүнд уур амьсгалын зохицуулалт, нүүрстөрөгчийн шингээлт, үер болон түймрээс хамгаалах, ургамлын тоос хүртээлт зэрэг багтана.
- c. **Соёлын үйлчилгээ:** Гоо зүйн мэдрэмж, уламжлалт экологийн үнэт зүйлс, амралт зугаалга болон оюун санааны үнэт зүйлс зэрэг хүний бие махбод болон сэтгэл санааны сайн сайхан байдалд нөлөөлдөг материаллаг бус зүйлс юм.

Эдгээр үйлчилгээг хэрэгжихүйц бодлогод тусгахын тулд тэдгээрийн үнэ цэнийг талуудад ойлгомжтой байдлаар илэрхийлэх ёстой. Үүнд:

1. Биофизик үнэ цэнэ:

Хэмжигдэхүйц, бодитой экологийн шинж чанарууд. Жишээлбэл: 100 га ой мод нь 1,500 тонн нүүрстөрөгчийн давхар ислийг шингээдэг. Энэ нь байгаль хамгааллын зорилтуудыг тодорхойлох суурь өгөгдөл болдог.

2. Мөнгөн үнэ цэнэ:

Экологийн ашиг тусыг санхүүгийн утгаар илэрхийлэх нь зардлын үр ашгийн шинжилгээнд тусгах боломжийг олгож, "байгалийн капитал"-ыг Сангийн яам болон олон улсын доноруудад ойлгомжтой болгодог.

3. Нийгэм-соёлын үнэ цэнэ:

Нийгмийн давуу эрх, соёлын онцлог болон хүний хэрэгцээг тусгасан мөнгөн бус үзүүлэлтүүд. Энэ нь эдийн засгийн үзүүлэлтүүдийн зэрэгцээ орон нутгийн иргэдийн эрх, оюун санааны үнэт зүйлсийг эн тэргүүнд тавих нөхцөлийг бүрдүүлдэг.

Гол зарчмууд ба хэрэгжүүлэх арга замууд

Экосистемийн үйлчилгээг газар нутгийн төлөвлөлтөд тусгахын тулд мэргэжилтнүүд хамгийн түрүүнд экосистемийн үндсэн бүтэц, үйл явц, чиг үүргээс эхлээд хүмүүсийн хүртэж буй үйлчилгээ хүртэлх бүх хэлхээ холбоог зураглах шаардлагатай. Байгаль нь өөр өөр оролцогч талуудын хувьд олон талт үнэ цэнийг агуулдаг гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм.

Байгалийн онцлог шинж чанарууд нь дараах байдлаар ангилагддаг:

- а. Хэрэглээний үнэ цэнэ (хүний хэрэгцээг хангах хэрэгсэл);
- а. Харилцан хамаарлын үнэ цэнэ (хүмүүсийн байгальтай болон байгалиар дамжуулан бие биетэйгээ тогтоосон харилцаан дээр суурилсан үнэ цэнэ);
- а. Дотоод үнэ цэнэ (байгаль орших төрөлх эрхтэй).

Плюралист (олон ургальч) хандлага нь бодлогын шийдвэр гаргахад зөвхөн хамгийн хүчтэй дуу хоолойтой талуудын үнэт зүйлд туйлширахаас сэргийлдэг.

Үнэлгээний арга зүйг сонгохдоо хамааралтай, найдвартай байдал болон нөөц бололцоонд тулгуурлан дүгнэж болно.

Үйлчилгээг хэмжиж, үнэлэхийн тулд бодлого боловсруулагчид дараах холимог аргуудыг ашиглах боломжтой:

БИОФИЗИК АРГУУД

Эдгээр нь байгалийн үйлчилгээ үзүүлэх физик чадавхыг үнэлдэг бөгөөд үндэсний хэмжээний тодорхой, бодитой зорилтуудыг (жишээ нь: нүүрстөрөгчийн ялгарлын суурь түвшинг үнэлэх эсвэл усны урсгалын зохицуулалт) тодорхойлоход хамгийн тохиромжтой. Зайнаас тандан судлах, амьдралын мөчлөгийн үнэлгээ, экологийн загварчлал болон биологийн олон янз байдлын голомт цэгүүдийн зураглал зэрэг хэрэгслүүдийг ашигладаг. Эдгээр аргууд нь шинжлэх ухааны хувьд найдвартай боловч заримдаа орон нутгийн хамаарлаас ангид байх талтай.



МЭДЛЭГТ СУУРИЛСАН АРГУУД

Эдгээр нь тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийг цогцоор нь хэрэгжүүлэх болон харилцан хамаарлын үнэ цэнийг тодорхойлоход нэн чухал юм. Орон нутгийн иргэд экосистемийг хэрхэн хүлээж авч, ашиглаж, үнэлж байгааг ойлгохын тулд оролцогч талуудын шууд оролцоонд тулгуурладаг. Энэ нь нутгийн уугуул болон орон нутгийн мэдлэгийг бодлогод нэгтгэх албан ёсны арга зам болдог. Жишээ нь: хэлэлцүүлэг-семинар, сонголт хийх туршилт, судалгаа болон оролцоонд суурилсан зураглал гаргах гэх мэт.

ТӨЛӨВ БАЙДАЛД СУУРИЛСАН АРГУУД

Зах зээлийн бодит зан төлөвийг ажиглах, экосистемээс хамааралтай эдийн засгийн хамаарлыг тодорхойлоход тохиромжтой. Хүмүүс цаг хугацаа, мөнгөө хэрхэн зарцуулж байгаад дүн шинжилгээ хийх замаар байгалийн хэрэглээний үнэ цэнийг хэмждэг. Жишээ нь: илэрхийлсэн давуу эрхийн техник, хедоник үнийн арга, аяллын зардлын арга болон нөхөн сэргээх зардлын тооцоолол.

ЦОГЦ АРГУУД

Далайн эргийн бүсийг хөгжүүлэх эсвэл өндөр уулын бүсэд зам барих зэрэг оролцогч талуудын хоорондох нарийн төвөгтэй зөрчлийг шийдвэрлэхэд зайлшгүй шаардлагатай. Шинжлэх ухааны өгөгдөл, зардал болон нийгмийн үр өгөөжийг нэгтгэн шийдвэр гаргах үйл явцыг бүрдүүлдэг. Энэ нь өөр өөр мэдлэгийн системүүдийг холбож, харилцан ашигтай шийдэл гаргахад тусалдаг. Жишээ нь: олон шалгуурт шинжилгээ, бүтэцийн шийдвэр гаргалт, мөнгөн үнэлгээний хэлэлцүүлэг болон нэгдсэн үнэлгээний загварчлал гэх мэт

Зөрчлийг бууруулах ба байгууллагуудад учрах сорилтууд

Экосистемийн үйлчилгээний үүргийг хүлээн зөвшөөрөх нь хамтын хэлэлцүүлгийг өрнүүлж, байгаль хамгааллыг хөгжилд саад учруулагч бус, харин харилцан хамааралтай хүчин зүйл гэж харахад тусална.

Эдгээр үнэлгээг зөвхөн хүлээн зөвшөөрөөд зогсохгүй, тэдгээрийн аудит болон уялдаа холбоог идэвхитэй дэмжихийн тулд засгийн газрууд экосистемийн үйлчилгээг ашиглах дараах стратегийн арга барил, бодлогын хэрэгслүүдийг нэвтрүүлж болно:

Үүнд:

ОРОН ЗАЙН ЧИГЛҮҮЛЭЛТ БОЛОН ЭКОЛОГИЙН БҮСЧЛЭЛ

Засгийн газрууд Экологийн онцгой бүсүүдийг тогтоох, эсвэл Үндэсний парк, Биологийн олон янз байдлын нөөц газар зэрэг байгаль хамгааллын нэн тэргүүний ач холбогдолтой газар нутгуудад анхаарал хандуулах замаар экосистемийн үнэлгээг туршиж болно. Энэ нь эрх бүхий байгууллагуудад үнэлгээ болон аудитын тогтолцоог үндэсний хэмжээний бодлого болгон өргөжүүлэхээс өмнө орон нутгийн түвшинд турших, боловсронгуй болгох, зохицуулах боломжийг олгоно.

БАЙГУУЛЛАГЫН АУДИТ БОЛОН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ

Хувийн хэвшлийг урамшуулахын тулд засгийн газрууд өөрсдийн үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх нөлөөлөлд (footprint) идэвхитэй аудит хийдэг, экологийг нөхөн сэргээхэд хөрөнгө оруулалт хийдэг компаниудад татварын чөлөөлөлт, татаас олгох эсвэл зах зээлд нэвтрэх давуу эрх олгож болно. Тухайлбал, "экологийн өр"-ийг эргүүлэн төлөх явдлыг ашиглан уугуул ургамалжилтыг хамгаалахаар сонгосон газар өмчлөгчид болон тариаланчдад татварын шууд хөнгөлөлт үзүүлэх замаар санхүүгийн аудитыг экологийн дагаж мөрдөх дүрэм журамтай шууд холбож өгөх боломжтой.

ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР БА УРАМШУУЛАЛ

Голын эхийн ой модыг хамгаалж, газрын доохи усны чанарыг хадгалж буй орон нутгийн иргэд эсвэл газар өмчлөгчдөд үзүүлж буй үйлчилгээнийх нь төлөө нөхөн олговор олгох.



БАЙГАЛИЙН КАПИТАЛЫН БҮРТГЭЛ

Экосистемийн үйлчилгээний үнэ цэнийг Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) зэрэг эдийн засгийн үндсэн тогтолцоонд нэгтгэх. Ингэснээр засгийн газрууд байгалийн баялгийнхаа нөхцөл байдлыг хянах, нөөцийг шавхаж буй салбаруудад хариуцлага тооцох боломжийг бүрдүүлнэ.

АМЬДРАХ ОРЧНЫ БАНК БА ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ (OFFSETS)

Хөгжүүлэгч, бүтээн байгуулагчид байгаль орчинд зайлшгүй учруулах нөлөөлөө өөр газарт ижил хэмжээний экологийн нөхөн сэргээлт хийх замаар нөхөн төлөхийг баталгаажуулах.

ЖЕНДЭРИЙН МЭДРЭМЖТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ХАНДЛАГА

Байгаль орчны өөрчлөлтийн үр ашиг болон ачаалал жигд бус хуваарилагддаг тул экосистемийн үйлчилгээг үнэлэх, удирдахад Жендэрийн эрх тэгш байдал ба нийгмийн оролцоог хангах (GESI) өнцгөөс хандах нь нэн чухал юм. Эмэгтэйчүүд, нутгийн иргэд болон бусад нийгмийн цөөнх бүлгүүд байгалийн нөөцөөс хамгийн их хамааралтай байдаг ч газар ашиглалтын шийдвэрт хамгийн бага оролцоотой, экосистемийн доройтлын үеийн нөхөн олговорт хамрагдах боломж нь хязгаарлагдмал байдаг. Засгийн газрууд болон олон улсын байгууллагууд экосистемийн үйлчилгээний бодлогод оролцоог хангах шалгуур үзүүлэлтүүдийг тусгах, задаргаат өгөгдөл ашиглах, нийгмийн төлөөлөл багатай бүлгүүдийг утга төгөлдөр оролцуулах замаар тэгш байдлыг бэхжүүлж чадна. GESI-д суурилсан хандлага нь байгалиас хамгийн их хамааралтай, байгалийн алдагдалд хамгийн өртөмтгий хүмүүсийг шийдвэр гаргах түвшинд оролцуулж, тогтвортой менежментээс үр шим хүртэх боломжийг бүрдүүлснээр экосистемийн үйлчилгээний засаглалын хууль ёсны байдал болон үр нөлөөг нэмэгдүүлдэг.

Шүүмжлэлийг шийдвэрлэх болон хөгжиж буй тогтолцоонууд

Экосистемийн үйлчилгээний тогтолцоо нь бодлого боловсруулахад өндөр үр ашигтай боловч хүн төвтэй байдал, байгалийг арилжааны хэрэгсэл болгох эрсдэл, мөн хүн зэрлэг амьтдын хоорондох зөрчил гэх мэт сөрөг үр дагавруудыг (disservices) тооцдоггүй зэрэг үндэслэл бүхий шүүмжлэлүүдтэй тулгарсаар ирсэн.

Эдгээр сорилтуудыг даван туулахын тулд байгууллагуудыг Байгалийн Хүнд Өгөх Өгөөж (БХӨӨ) - (Nature's Contributions to People - NCP) тогтолцоо руу шилжихийг зөвлөж байна. БХӨӨ тогтолцоог Биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээний засгийн газар хоорондын шинжлэх ухаан-бодлогын платформ (IPBES) нэвтрүүлсэн бөгөөд үүнийг экосистемийн үйлчилгээний (ЭҮ) - (ES) тогтолцооны залгамж халаа гэж үзэж болно. Энэ нь илүү хүртээмжтэй, олон талт, соёлд суурилсан байхыг зорьдог.

БХӨӨ тогтолцооны гол зарчмууд

- БХӨӨ гэдэг нь амьд байгалийн хүний амьдралын чанарт оруулж буй эерэг болон сөрөг бүхий л хувь нэмрийг хэлнэ.
- Соёлын үйлчилгээг тусдаа нэг ангилалд авч үздэг ЭҮ тогтолцооноос ялгаатай нь БХӨӨ нь соёлыг хүн ба байгалийн хоорондын харилцан үйлчлэл бүрт шингэсэн гэж үздэг. Соёлын ертөнцийг үзэх үзэл нь материаллаг, зохицуулах болон материаллаг бус өгөөжийг хэрхэн хүлээн авч, үнэлж, ашиглахад нөлөөлдөг.
- БХӨӨ нь нүүдэлчин малчдын эртний уламжлал, онцлог шинжийг дэмжих, уламжлалт анчид болон байгалийн тодорхой тогтоц, газар нутаг, амьтны төрөл зүйлтэй тогтоосон ариун нандин холбоо гэх мэт байгалийн хүний амьдралд оруулж буй материаллаг бус хувь нэмрийг чухалчилдаг.
- БХӨӨ нь хүн-зэрлэг амьтдын хоорондын зөрчил гэх мэт хүмүүсийн байгалиас мэдэрч буй сөрөг нөлөөлөл эсвэл зардлыг тодорхой тусгадаг. Шударга байгаль хамгааллын бодлого боловсруулахад эдгээр бодит байдлыг хүлээн зөвшөөрөх нь нэн чухал юм.

БХӨӨ тогтолцоог хэрэгжүүлэхийн тулд бодлого боловсруулагчид болон мэргэжилтнүүд үнэлгээ, төлөвлөлтийн арга зүйгээ дараах байдлаар өөрчлөх шаардлагатай:

- a. Байгалийн ашиг тусыг эдийн засгийн хязгаарлагдмал ангилалд хүчээр оруулахын оронд үнэлгээний аргууд (илэрхийлсэн давуу эрх эсвэл зөвшилцлийн аргууд гэх мэт) олон талт үнэлгээг ашиглаж болно. Төлөвлөгчид орон нутгийн иргэдийн бодит ертөнцийг үзэх үзэл, уламжлал, үнэт зүйлийг чухалчилсан зөвшилцөх, хүүрнэх болон оролцооны аргуудыг ашиглаж болно. Үүнд нутгийн мэдлэгийн тогтолцоог шинжлэх ухааны өгөгдөлтэй нэгтгэж, тэдгээрийг ганц мөнгөн дүнгээр илэрхийлэлгүйгээр харилцан хамааралтай болон дотоод үнэ цэнийг нь тодорхойлох явдал багтана.
- b. Хөгжлийн төслийг үнэлэхдээ төлөвлөгчид зөвхөн мод бэлтгэлийн алдагдал, биологийн олон янз байдлын бууралт зэрэг материаллаг зардлыг тооцохоос гадна ариун дагшин газрыг сүйтгэх, эсвэл иргэдийн соёлын онцлогт үзүүлэх нөлөө зэрэг материаллаг бус зардлыг тооцож чаддаг байх хэрэгтэй.
- c. Бодлогыг эрх мэдлийн тэнцвэргүй байдлыг арилгах, байгалийн үр өгөөжийг шударга, тэгш хуваарилахыг дэмжих тодорхой зорилготойгоор боловсруулж болно. Энэ нь үнэлгээ өгөх болон шийдвэр гаргах үйл явцад эрх эзэмшигчдийн бодит оролцоог хангах бөгөөд байгаль хамгааллын мөргөлдөөний зардлыг гадуурхагдсан болон орон нутгийн иргэд үүрч, харин үр ашгийг нь гадны талууд хүртэх явдлаас сэргийлнэ.

БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ NO. 17:

Байгаль хамгааллын ландшафт дахь оролцоон дээр суурилсан мониторинг, үнэлгээ (PM&E)



Удиртгал ба үндэслэл

Байгаль хамгаалал үр дүнтэй байх нь хэрэгжүүлж буй үйл ажиллагааг хэрхэн оновчтой, үр ашигтай явуулж байгаа болон тавьсан зорилгодоо хүрч буй эсэхийг тодорхойлдог Мониторинг, үнэлгээнээс шууд хамаардаг. Мониторинг үнэлгээний уламжлалт аргууд нь өөрчлөлтийн онол болон шалтгаан үр дагаврын зураглалд суурилсан дээрээс доош чиглэсэн арга замаар хэрэгжиж ирсэн бөгөөд үүнд орон нутгийн иргэдийг эрх тэгш түнш гэхээсээ илүүтэй идэвхигүй мэдээллийн эх сурвалж эсвэл төслийн үр шим хүртэгчид төдийхнөөр оролцуулж ирсэн билээ. Мониторинг Үнэлгээний эдгээр уламжлалт арга нь төслийн албан ёсны тайлан болон газар дээрх бодит нөхцөл байдлын хооронд зөрүү үүсгэх нь түгээмэл байдаг бөгөөд энэ нь цаасан дээр экологийн хувьд зөв мэт харагдах боловч бодит байдал дээр тогтвортой бус арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд хүргэдэг.

Оролцоонд суурилсан мониторинг үнэлгээ (Participatory Monitoring & Evaluation) гэдэг нь нутгийн иргэдийн оролцоотой, тэдэнд хүндэтгэлтэй байх зарчимд суурилсан арга зүй юм. Ингэснээр нутгийн иргэд өөрсдөө тухайн хяналт үнэлгээний чухал асуултуудыг шийдвэрлэж, мэдээлэл цуглуулах арга замаа тодорхойлон, хяналтын өгөгдөлд дүн шинжилгээ хийж, төслийн үйл ажиллагааг засаж залруулахад шаардлагатай ололт амжилт болон тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох юм.



Оролцоонд суурилсан мониторинг үнэлгээ (ОСМУ) нь хүртээмжтэй, ёс зүйтэй, олон нийтэд түшиглэсэн үйл ажиллагаа руу төсөл хөтөлбөрийг чиглүүлж өгдөг. Мөн нутгийн иргэдийг юуг хянах, мэдээллийг хэрхэн тайлбарлах, үр дүнд хэрхэн дасан зохицох, гарсан үр дүнг менежментэд хэрхэн ашиглахыг тодорхойлдог идэвхитэй шийдвэр гаргагчид болгодог. ОСМУ-г хэрэгжүүлэх нь зөвхөн мэдээллийн чанарыг сайжруулах эсвэл нөхцөл байдалд илүү нийцсэн үзүүлэлтүүдийг бий болгох стратегийн сонголт биш юм; энэ нь тухайн газар нутагт амьдарч буй хүмүүсийн эрх, бүрэн эрхт байдал болон уламжлалт экологийн мэдлэгийг хүндэтгэж буй ёс зүйн зайлшгүй шаардлага юм. Засгийн газар, олон талт байгууллагууд болон бусад дэмжигчдийн хувьд ОСМУ нь орон нутгийн байгаль хамгааллын хүчин чармайлтыг Үндэсний биологийн олон янз байдлын стратеги төлөвлөгөө (NBSAP), Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDG), Куньмин-Монреалийн дэлхийн биологийн олон янз байдлын тогтолцоо (GBF) зэрэг олон улсын гэрээ конвенциудтай уялдуулах хүчтэй механизм болж чадна. Бодлогын чиг үүргийг бодит амьдралтай холбосноор ОСМУ нь төвлөрлийг сааруулсан засаглалыг дэмжиж байгаль хамгааллын зөрчлүүдийг багасгах, хариуцлагыг сайжруулан олон улсын нийгмийн болон байгаль орчныг хамгаалах ажлын гүйцэтгэлийг сайжруулахад ач холбогдолтой юм. Энэ нь байгаль хамгааллын үр дүнг зөвхөн шинжлэх ухаанчаар хэмжээд зогсохгүй мөн нийгмийн хууль эрхтэй нийцсэн орон нутгийн иргэдийн өмчлөл бүхий эрх тэгш байдлыг бий болгодог юм.

ОСМУ-ний ач холбогдол

ОСМУ-г загварыг ашиглах нь байгаль хамгааллын мэргэжилтнүүд болон орон нутгийн оролцогч талуудын аль алинд нь урт хугацааны хэд хэдэн давуу талыг бий болгодог. Үүнд:

МЭДЭЭЛЛИЙН ЧАНАР БОЛОН ХАРИУ ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ ЧАДВАР САЙЖРАХ

Байгаль хамгааллын үйл ажиллагаанд шууд өртөж буй хүмүүсийг санал асуулгад хамруулах нь үнэн зөв, орон нутгийн нөхцөл байдалд суурилсан өгөгдөл цуглуулахад чухал ач холбогдолтой бөгөөд шинээр гарч ирж буй орон нутгийн шинжтэй тулгамдсан асуудлыг шуурхай илрүүлэх боломжийг олгодог. Жишээ нь, тухайн ландшафтаар өдөр бүр явдаг орон нутгийн малчид эсвэл ойн нөөц ашиглагчид нь зэрлэг амьтдын үржлийн зан төрх дэх өөрчлөлт, хууль бус үйл ажиллагаа, эсвэл шинээр гарч ирж буй өвчин эмгэгийг үе үе хийгддэг шинжлэх ухааны судалгаанаас хамаагүй хурдан илрүүлж чаддаг. Энэ нь төрийн байгууллагуудын хувьд албан ёсны хяналтын сүлжээнд нь тус болж, алслагдмал нутаг дахь чухал мэдээллийг зардал багатайгаар олж авах боломжийг олгодог.

ОЛОН НИЙТИЙН ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ БА ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ

ОСМУ нь эмэгтэйчүүд, залуучууд, нутгийн уугуул иргэд болон бусад нийгэмд төлөөлөл багатай бүлгүүдийн дуу хоолойг бодитойгоор сонсох нөхцөлийг бүрдүүлдэг. ОСМУ нь тэдэнд өөрсдийн амьжиргаа, уламжлалт зан заншилд шууд нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргахад оролцох эрхээ эдлэх боломжийг олгодог. Орон нутгийн иргэд үнэлгээний явцад хувь нэмрээ оруулснаар байгаль хамгааллын асуудлыг эсэргүүцэх болон аливаа зөрчил мэдэгдэхүйц буурдаг. Энэ нь нийгмийн хамгааллын эн тэргүүний бодлогуудтай нягт уялдаж, байгаль хамгаалал болон хөгжлийн үр дүн тэгш хүртээмжтэй байх баталгаа болдог.



ХҮЙСИЙН МЭДРЭМЖТЭЙ, ХҮРТЭЭМЖТЭЙ ҮР ДҮН

Хүйсийн мэдрэмжтэй ОСМУ нь мэдээлэл цуглуулахад эмэгтэйчүүдийг зүгээр нэг оролцуулахаас илүү өргөн хүрээг хамардаг. Энэ нь тэдний оролцоог хязгаарлаж буй саад тотгорууд, тэр дундаа цаг хугацааны ачаалал, нийгмийн хэм хэмжээ зэргийг тодорхойлж, энэхүү саад бэрхшээлүүдийг бууруулдаг. Хүйсийн дүн шинжилгээг төслийн загвар болон үйл явцад нэгтгэснээр ОСМУ нь байгаль хамгааллын үйл ажиллагааны эмэгтэйчүүд, залуучууд болон бусад төлөөлөл багатай бүлгүүдэд үзүүлэх ялгаатай нөлөөллийг илрүүлэхэд тусалдаг. Хүйсийн мэдрэмжтэй хандлага нь бодлого боловсруулагчдад хүйсийн тэгш байдлын талаарх олон улсын амлалтуудаа (жишээ нь: ТХЗ-ын 5-р зорилт) биелүүлэх механизмыг бүрдүүлж өгдөг.

ИТГЭЛЦЭЛ БА ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ

Энэхүү үйл явц нь байгаль хамгааллын мэргэжилтнүүд болон орон нутгийн иргэдийн хооронд харилцан итгэлцэл, хариуцлагын тогтолцоог бэхжүүлж, орон нутгийн чадавхи, техникийн ур чадвар, манлайллыг бий болгодог. Энэ нь төслийн хэрэгжилтэд хяналт тавих урт хугацааны зардлыг эрс бууруулж, санхүүжүүлэгчдийн хувьд төсөл дууссаны дараах тогтвортой байдлыг хангадаг.

МЭДЭЭЛЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЁС ЗҮЙ

ОСМУ нь нутгийн иргэдийн мэдээллийн бүрэн эрхт байдлыг хангахад шууд хувь нэмэр оруулж, энэхүү мэдээллийг ёс зүйтэйгээр ашиглах боломжийг олгодог. Энэ нь мөн төрийн үйл ажиллагаанд уламжлалт эрхийг хүндэтгэх, хүний эрхийн талаарх олон улсын үүргээ биелүүлэхэд тусалдаг.

Үндсэн зарчмууд

ОСМУ-г амжилттай хэрэгжүүлэхийн тулд хөтөлбөрийн эхэн үеийн үйл ажиллагаанаас эхлэн нутгийн иргэдтэй хамтран бий болгох стратегийг барьж ажиллах ёстой. Үүнд дараах үндсэн зарчмуудыг баримтална:

Шалгуур үзүүлэлтүүдийг хамтран боловсруулах

Байгаль хамгаалах төсөл хөтөлбөрүүдийн үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтүүдийг оролцогчид хамтран тодорхойлж, сонгох ёстой. Эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь орон нутгийн нэн тэргүүний зорилтууд болон төслийн хэрэгцээг аль алиныг нь тусгасан байх шаардлагатай бөгөөд SMART (Тодорхой, Хэмжигдэхүйц, Биелэгдэхүйц, нөхцөл байдалд тохирсон, тодорхой хугацаатай) шалгуурыг хангасан байна. Засаг захиргааны ажилтнууд болон төсөл хөтөлбөрт оролцогч талууд энэхүү хэлэлцүүлэгт байлцаж, орон нутгийн шалгуур үзүүлэлтүүд нь үндэсний тайлагналын шаардлагад нийцсэн байхад анхаарахаас гадна байгууллагын логик тогтолцоотой (logframes) сайн уялдуулах ёстой.

Уян хатан мэдээлэл цуглуулах аргууд

ОСМУ нь тухайн төслийг том зургаар нь харах боломжийг олгодог холимог аргуудыг ашигладаг, дасан зохицох чадвартай хэрэгсэл юм. Мэдээлэл цуглуулах аргууд нь орон нутгийн иргэдийн сонголттой нийцсэн байх ёстой бөгөөд фокус бүлгийн хэлэлцүүлэг, ярилцлага, олон нийтийн семинараас эхлээд гэрэл зураг, видео бичлэг ашигласан WhatsApp-н бүлгүүд гэх мэтчилэн өргөн хүрээг хамарч болно. Төрийн байгууллагууд эдгээр аргуудыг харилцан холбоотой ажиллах нөхцөлийг бүрдүүлж иргэдийн мэдээлэл өмчлөх эрхийг алдагдуулахгүйгээр олон нийтийн мэдээллийг үндэсний мэдээллийн санд саадгүй нэгтгэх боломжийг хангаж чадна.

Хамтын дүн шинжилгээ ба үйл ажиллагаа

Нутгийн иргэдэд мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхэд сургалт болон дэмжлэг шаардлагатай байж болно. Иргэдэд шаардлагатай сургалт, тоног төхөөрөмжийг олгох ёстой. Судалгааны үр дүнг тухайн иргэдэд хүртээмжтэй байдлаар буюу аудио-видео хэлбэрээр эргэн танилцуулах ёстой. Ингэснээр тэд төслийн дараагийн шатны зохицуулалт, нөөцийн хуваарилалт болон цаашдын засаж залруулах үйл ажиллагаанд мэдээлэлтэйгээр оролцох боломж бүрдэнэ. Засаг захиргааны эрх бүхий байгууллагууд эдгээр үйл явцыг хамтран чиглүүлж, санал хүсэлтийн тогтолцоог захиргааны тогтмол хяналт шалгалтын нэг хэсэг болгон албажуулж, төслийн дасан зохицох менежментийг дэмжих боломжтой.

ОСМУ-г практикт хэрэгжүүлэх нь

1-р үе шат:

Оролцогч талуудыг тодорхойлох ба хамтрах

- i. Байгаль хамгааллын санаачилгад өртөж буй эсвэл оролцож буй бүх талуудыг тодорхойлохын тулд оролцогч талуудын нарийвчилсан зураглалыг гаргах шаардлагатай. Үүнд албан ёсны бүлгүүдээс гадна байгалийн нөөцөөс шууд хамааралтай, өдөр тутмын амьдрал нь байгаль хамгааллын зорилтуудтай шууд огтолцдог туслах бүлгүүдийг (жишээ нь: малчид, ойн дагалт баялаг цуглуулагчид, загасчид гэх мэт) тодорхойлно.
- ii. Эмэгтэйчүүд, хүүхэд залуучууд, нутгийн иргэд болон бусад нийгмийн төлөөлөл багатай гишүүдийн дуу хоолойг идэвхитэй оролцуулах нөхцөлийг бүрдүүлнэ. Тодорхой бүлгүүд нээлттэй ярихаас цааргалж болох бөгөөд орон нутгийн эрх мэдлийн динамик болон шатлан захирах ёсыг саармагжуулахын тулд тусдаа семинар эсвэл фокус бүлгийн хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлагатай байж болно.
- iii. Цаг хугацааны хязгаарлалт, гадны хүмүүстэй харилцаж байсан өмнөх сөрөг туршлага, өөртөө итгэлгүй байдал зэргээс үүдэлтэй эргэлзээг даван туулахын тулд ОСМУ-ний зорилго, гүйцэтгэх үүрэг, шууд ашиг тусыг тайлбарлан таниулж, сайн дурын үндсэн дээр идэвхитэй оролцох баталгааг хангана.

2-р үе шат:

Шалгуур үзүүлэлтүүдийг хамтран боловсруулах ба түншлэл

- i. Орон нутгийн нэн тэргүүний зорилтууд, үнэт зүйлс болон төслийн хэрэгцээг тусгасан үзүүлэлтүүдийг хамтран боловсруулах семинаруудыг зохион байгуулна. Шаардан тулгахын оронд юуг амжилт, юуг алдаа гэж үзэхийг орон нутгийн иргэд өөрсдөө шийдэх боломжийг олгож болно. Жишээ нь: Донор байгууллага тусгай хамгаалалттай газар нутгийг эн тэргүүнд тавьж байхад, орон нутгийн иргэд усны хүртээмжийг сайжруулах эсвэл зэрлэг амьтад тариалангийн талбай руу халдсан тохиолдлыг бууруулахыг амжилтын гол үзүүлэлтээр сонгож болно.
- ii. Хамтран сонгосон үзүүлэлтүүд нь SMART шалгуурыг хангасан байх бөгөөд ингэснээр цаг хугацааны явцад найдвартай хянах боломжтой болно.
- iii. Эдгээр сонгосон шалгуур үзүүлэлтүүдийг илүү өргөн хүрээнд тайлагнах болон байгууллагын логик тогтолцоотой уялдуулахын тулд төрийн байгууллагууд болон олон талт түншүүдийг энэхүү хэлэлцүүлэгт оролцуулна.

3-Р ҮЕ ШАТ: МОНИТОРИНГ ЯВУУЛАХ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ БА МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

- i. Мэдээллийг хэрхэн цуглуулах талаар нэгдсэн ойлголтод хүрнэ. Мэдээлэл цуглуулах аргууд нь орон нутгийн иргэдийн сонголт, тав тух болон дэд бүтцэд нийцсэн байна. Хэлбэрүүд нь фокус бүлгийн хэлэлцүүлэг, ярилцлага, семинар эсвэл гэрэл зураг, видео ашигладаг гар утасны аппликейшн хүртэл байж болно. Төрийн байгууллагууд эдгээр хэрэгслүүдийг орон нутгийн иргэдийн өмчлөх эрхийг алдагдуулахгүйгээр үндэсний мэдээллийн сантай нийцүүлэх боломжтой.
- ii. Байгаль хамгааллын мэргэжилтнүүд болон төслийн менежерүүд иргэдийг тасралтгүй сургалт, нөөц бололцоо, тоног төхөөрөмжөөр хангаснаар орон нутгийн иргэд мэдээллийг үр дүнтэй, аюулгүй цуглуулах техникийн мэдлэг, чадвар, итгэл үнэмшилтэй болно.
- iii. Мэдээлэл цуглуулах үйл ажиллагааг орон нутгийн иргэдийн амьжиргааны хэв маягт тохируулан төлөвлөснөөр тэдний орлого, амьдралд сөргөөр нөлөөлөхгүй байхыг анхаарна. Жишээ нь: Малчид отор нүүдлээр явах үеийг давхцуулахгүй байх гэх мэт.

4-Р ҮЕ ШАТ: МЭДЭЭЛЛИЙН МЕНЕЖМЕНТ, ХАМТЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ БА ТАЙЛАН

- i. Нутгийн иргэдийн мэдээллийн бүрэн эрхт байдлыг хангах: Мэдээлэл хамгаалах тодорхой протоколуудыг бий болгохын зэрэгцээ орон нутгийн иргэд өөрсдийн мэдээллийг өмчлөх эрхээ хадгалж үлдэх, мөн тухайн мэдээллийг хэрхэн удирдах, хадгалах, гадагш хуваалцах талаар ил тод зөвшөөрөл өгөх нөхцөлийг бүрдүүлнэ.
- ii. Оролцогчдыг мэдээлэлд дүн шинжилгээ хийх үндсэн аргуудад сургах: Цуглуулсан мэдээллийг хөндлөнгийн шинжээчдэд шууд шилжүүлэхийн оронд иргэд өөрсдөө хамтран тайлбарлаж чаддаг болохын тулд дүн шинжилгээний анхан шатны аргуудад сургана. Шинжлэх ухааны процессыг ийнхүү иргэдэд ойлгомжтой болгох нь өгөгдлийн тайлбар бодит нөхцөл байдалд нийцсэн, үнэн зөв байх баталгаа болдог.
- iii. Судалгааны үр дүнг иргэдэд эргэн танилцуулах: Зөвхөн эрдэм шинжилгээний хэллэг ихтэй, статистикийн зузаан тайланд найдах бус, орон нутгийн иргэдэд хамгийн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр үр дүнг танилцуулна.
- iv. Фокус бүлгийн хэлэлцүүлгийг чиглүүлэх: Судалгааны үр дүнг хэлэлцэх, санал хүсэлт цуглуулах, үр дүнд тулгуурлан арга хэмжээ авах зорилгоор фокус бүлгүүдийг ажиллуулна. Ингэснээр төслийн үйл ажиллагаа, нөөцийн хуваарилалтад шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулж, тасралтгүй засаж залруулах боломжтой болно. Төрийн байгууллагууд эдгээр үйл явцыг хамтран чиглүүлж, санал хүсэлтийн тогтолцоог захиргааны тогтмол хяналт шалгалтын нэг хэсэг болгон албажуулснаар олон нийтийн санал санаачилга бодит ажил хэрэг болж байгааг харуулах ач холбогдолтой.



Байгууллагын түвшний сорилтуудыг даван туулах нь

ОСМУ нь урт хугацааны тогтвортой үр ашиг, ёс зүйтэй хандлагыг санал болгодог хэдий ч итгэлцэл бий болгох, чадавхыг бэхжүүлэх болон харилцааг удирдахад эхний шатанд ихээхэн хэмжээний цаг хугацаа шаарддаг. Энэ нь заримдаа уламжлалт санхүүжилтийн горимд хүлээлт үүсгэх мөн төлөвлөгөөт хугацаатай зөрчилдөж болно. ОСМУ-г төлөвлөх, хэрэгжүүлэхдээ дараах зүйлсийг анхаарах нь чухал юм:

1. ОСМУ нь уламжлалт Хяналт шинжилгээ Үнэлгээтэй харьцуулахад цаг хугацаа болон нөөц их шаарддаг. Энэ нь богино хугацааны санхүүжилтийн мөчлөгт багтаан хурдан, тоогоор хэмжигдэхүйц үр дүн хүсэж буй доноруудын тайлант хугацаатай зөрчилдөх тохиолдол гардаг. Гэсэн хэдий ч энэ нь алсдаа төслийн бүтэлгүйтэл, орон нутгийн эсэргүүцэл болон хууль сахиулахтай холбоотой ирээдүйд гарч болох зардлыг мэдэгдэхүйц бууруулдаг. Энэхүү зөрчлийг зөөлрүүлэхийн тулд олон талт байгууллагууд болон засгийн газрын төлөвлөлтийн комиссууд төслийн эхлэлийн үе шатыг уян хатан тогтоож, бодит хугацаа төлөвлөн, оролцооны суурь ажлуудыг гүйцэтгэхэд зориулсан тусгай төсвийн нэгжийн санхүүжилтдээ тусгаж өгөх боломжтой.



2. ОСМУ нь орон нутгийн тэргүүлэх зорилтууд болон суралцах үйл явцад төвлөрдөг тул үр дүнг тэр бүр урьдчилан таамаглах боломжгүй байдаг. Энэ нь дээрээс доош чиглэсэн тогтсон үзүүлэлт болон баталгаатай үр дүнд дассан доноруудын зүгээс эсэргүүцэлтэй тулгарахад хүргэж болзошгүй. Донорууд болон засаг захигааны байгууллагууд нь хатуу хяналтын цэгүүдээс татгалзаж, үр дүнд суурилсан, уян хатан үнэлгээ бүхий "Дасан зохицох менежмент"-ийн тогтолцоог нэвтрүүлснээр энэ асуудлыг шийдэж чадна.
3. Байгаль хамгааллын мэргэжилтнүүд ОСМУ-г байгууллагын түвшинд сурталчлан таниулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Мэргэжилтнүүд ОСМУ –ний урт хугацааны ашиг тус, мэдээллийн бодит байдал болон ёс зүйн зайлшгүй шаардлагын талаарх мэдлэгийг тогтмол өгснөөр доноруудын хандлагыг олон нийтээр удирдуулсан тогтвортой үнэлгээний тогтолцоог дэмжих зүгт өөрчилж чадна. ОСМУ –ний удирдамжийг стандарт үйл ажиллагааны журам (SOP), үндэсний бодлогын хүрээ болон донорын санхүүжилтийн зааварт тусгаснаар мэргэжилтнүүд байгаль хамгааллын парадигмыг илүү тогтвортой, мэдээллийн хүчинтэй байдал болон ёс зүйн шаардлагыг хангасан, олон нийтэд түшиглэсэн үнэлгээний тогтолцоо руу шилжүүлж чадах юм.

Бодлогын зөвлөмжийг боловсруулахад гол хувь нэмэр оруулсан хүмүүс (цагаан толгойн үсгийн дарааллаар)

Abdul Wali Atif (National Environmental Protection Agency, Afghanistan)
 Benazir Kabaeva (Snow Leopard Foundation in Kyrgyzstan)
 Bermit Tursunkulova (American University of Central Asia)
 Bohdan Prots (Danube-Carpathian Programme)
 Charudutt Mishra (International Snow Leopard Trust)
 Chloe Lucas (International Snow Leopard Trust)
 Deepshikha Sharma (Nature Conservation Foundation)
 Farwiza Farhan (Yayasan HAKA)
 Gustaf Samelius (International Snow Leopard Trust)
 Hamed Safi (National Environmental Protection Agency, Afghanistan)
 Hem Sagar Baral (International Snow Leopard Trust)
 Hotlin Ompusunggu (Healthy Planet Indonesia)
 Inza Kone (Félix Houphouët-Boigny University)
 Javed Mohammad Iqbal (Peace Schans)
 Jennifer Snell Rullman (International Snow Leopard Trust)
 José Hernán Sarasola (CECARA)
 Juliette Young (INRAE)
 Justine Shanti Alexander (Wildlife Conservation Society)
 Karen Aghababayan (BirdLinks Armenia)
 Karma Sonam (Nature Conservation Foundation)
 Koustubh Sharma (International Snow Leopard Trust)
 Kubanychbek Jumabay Uulu (Snow Leopard Foundation in Kyrgyzstan)

Kulbhushansingh Suryawanshi (Nature Conservation Foundation)
 Laura Marina Reyes (Global Penguin Society)
 Lutfullah Sahibzada (National Environmental Protection Agency, Afghanistan)
 Manu Neelkandhan (IdeaCulture India)
 Matthaias Fiechter (Cartier Foundation)
 Muhammad Ali Nawaz (Snow Leopard Foundation-Pakistan)
 Natalie Schmitt (WildTechDNA/McMaster University)
 Oliver Wearn (International Snow Leopard Trust)
 Orjan Johansson (International Snow Leopard Trust)
 Phub Dorje (Nature Conservation Division)
 Rodrigo A. Medellin (Global South Bats)
 Pablo García Borboroglu (Global Penguin Society)
 Ranjini Murali (Humboldt University)
 Ravo Tsrinantoanina (Conservation Fusion)
 Seema Seth (Studio Sky)
 Shivani Bhalla (Ewaso Lions)
 Stanzin Namgail (University of Ladakh)
 Suri Venkatachalam (International Snow Leopard Trust)
 Susie Louis (Conservation Fusion)
 T Shahzad (Snow Leopard Foundation, Pakistan)
 Toby Otieno (Ewaso Lions)
 Ulukbek Visid Uulu (American University of Central Asia)
 Varun R. Goswami (Conservation Initiatives)

Санхүүжүүлэгч: Дарвины Санаачлага

ФОТО КРЕДИТ: Farwiza Farhan Justine Alexander Koustubh Sharma Lawrie Brailey Rachel Graham Sonam Tashi Lama Vatsoa Rakotondrazafy

ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН: Miraya Vadra

ТЭНГЭР СТУДИЙН ДЭЗАЙН: Adya Shivakumar Ayushi Vakharia Inshra Khan Seema Seth

